

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1	“Мон – Энержи Консалт” ХХК-ийн Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл магадлангаар хянагдаж Барилга хөгжлийн төвийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ерөнхий дүгнэлтийг гаргуулахаар бэлтгэж байна.	100%
2	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дарга Цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг олгох ЭХЯ-ны ажлын хэсэгт биечлэн уулзалт зөвлөгөөн хийж, холбогдох асуудлуудыг шийдвэрлүүлэн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг гаргуулж, зураг төслийн ерөнхий захиалагч болох БХБЯ-нд хүлээлгэн өгсөн.	100%
3	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	“Нутаг консалтинг” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын зураг төслийн гүйцэтгэлд хяналт тавьж эрчимжүүлэх ажлын хүрээнд ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөлийг хангагч байгууллагатай зөвшилцөж, ажлын зураг төсөлд шаардлагатай цэвэр бохир усны техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах тухай 3/1179 дугаартай албан бичгийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр “Багануур Ус” ААТҮГ-т хүргүүлсэн. БҮТП-ийн үйлдвэрийн албан конторын барилгын зураг төсөл магадлангаар хянагдаж дууссан ба одоогоор зураг төслийн төсөвт магадлал хийгдэж байна.	100%
4	БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалын 02 дугаар хавсралтын дагуу БҮТП-ийн стратеги төлөвлөгөөний нэгдүгээр бүлгийн төслийг БҮТП-ийн Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтнээр хянуулан нэмэлт өөрчлөлтийг тусгаж шаардлагатай өөрчлөлтийг хийж байна.	100%
5	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1	Байгууллагын дүрмийн төслийг боловсруулан НЗДТГ-т танилцуулахаар бэлтгэж байна.	100%
6	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.3	Парк нь ЖДҮДТ-тэй хамтын ажиллагааныхаа хүрээнд шинэ техник технологийн мэдээллийн сангийн жагсаалтыг цахим хаягаар хүргүүлэв.	100%
7	ННЗБ-уудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт	ННЗБ-уудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын дагуу дараах биелэлтүүдийг нэгтгэж хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд : 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт, дүн мэдээ 2. Хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан 3. Байгууллагын 3 дугаар сарын төлөвлөгөөний биелэлт, 4 дүгээр сарын төлөвлөгөө 4. Нийслэлийн 4 дүгээр сарын захирамжийн биелэлт	100%
8	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

		“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 18 бичиг ирснээс хариутай бичиг 10, хариугүй бичиг 8, хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас яам, нийслэл, аж ахуй нэгж, байгууллагуудад 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 20 албан бичиг явуулсан ба явсан бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна.	
9	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	Байгууллагын baganuur-itr.mn цахим хуудасны хөгжүүлэлт, баяжилтыг тогтмол хийж цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг тухай бүрт нь байршуулан ажилласан.	100%
10	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> - 2020 оны 1 дүгээр улирлын тайлан, балансыг гаргаж НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан. - Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын шилэн дансны мэдээллийг тогтоосон агуулга, стандартын дагуу байршуулсан. - Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бусад ажил үүргийг хугацаанд нь гүйцэтгэж ажилласан. 	100%
НЭМЭЛТ АЖИЛ			
11	Багануур дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг БҮТП-ын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны 57 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		100%
12	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг долоо хоног бүр нэгтгэн гаргаж пүрэв гараг болгон zendmaal@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.		100%
13	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах тухай” А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног тутам гаргаж НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.		100%
14	Нийслэлийн архивын газарт байгууллагын 2019 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлал буюу тушаалын баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх төлөвлөгөөний дагуу Archive eDoc системд бүрдүүлэлтийг хийн нягтлан шалгаж бүртгэлийг хүргүүлсэн.		100%
15	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд тусгах “ Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-д цахим систем ашиглан үнэлгээ хийн БҮТП-ийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны 73 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		100%
16	Шинэ корона вирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үүрэг, чиглэл, тогтоол, шийдвэр, захирамжуудын хэрэгжилтийг хангах үүднээс зохион байгуулагдаж буй явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг өдөр бүр Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ubhealth2020@gmail.com цахим хаягаар, дүүргийн Онцгой байдлын хэлтэст 7021101 утсаар болон Шуурхай штабт тус тус тайлагнан ажиллаж байна. Мөн явган эргүүлийн 7 хоногийн нэгтгэсэн мэдээг 7 хоног бүр НЗДТГ-т battsojubcity@gmail.com цахим хаягаар хүргүүлэн ажиллаж байна.		100%
17	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвөөс ирсэн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 179 дугаартай албан бичгийн дагуу “Сүрьеэгүй дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд байгууллагын нийт албан хаагчдаас Сүрьеэ өвчний эрсдэлт хүчин зүйлсийн асуумжийг авч, БҮТП-ийн 04 дүгээр сарын 13-ны өдрийн 66 тоот албан бичгээр асуулт бүрээр нэгтгэсэн дүн мэдээг хүргүүлсэн.		100%

18	Дүүргийн удирдах ажилтнуудын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн шуурхай хуралдаанаар дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо оролцож цэвэрлэгээний тайланг БҮТП-ийн 2020 оны 04 дүгээр сарын 04-ний 63 дугаартай албан бичгээр Багануур хотын Захирагчийн албанд хүргүүлэв.	100%
----	---	------

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Laywit

Б. НОМИНЗУЛ